

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/096/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2026.02.25</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn Аудитор: А.Адилзаяа Утас: 80870886 Цахим хаяг: Adilzayaa@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2026.02.25 № 2/96

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд нийт 27 ажил төлөвлөснөөс хэрэгжилтийн хувь 93.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТӨРГҮҮЛӨХ
АУДИТОР / Б.МӨНХБАТ



АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОЯ	Байгаль орчны яам
БОУАӨС	Байгаль орчин үүр амьсгалын өөрчлөлтийн сайд
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	343,564,204.00	285,782,225.39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	237,050,007.00	168,043,658.49
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	237,050,007.00	168,043,658.49
3121	Төгрөг	237,050,007.00	168,043,658.49
31211	Төрийн сангийн харилцах	237,050,007.00	168,043,658.49
33	АВЛАГА	18,000.00	163,508.00
335	Бусад авлага	18,000.00	163,508.00
3351	Байгууллагаас авах авлага	18,000.00	163,508.00
35	БАРАА МАТЕРИАЛ	106,496,197.00	117,575,058.90
351	Түүхий эд материал	4,950,840.00	10,533,261.90
35110	Тусгай зориулалттай материал	4,867,340.00	10,424,761.90
35130	Эм боох материал	83,500.00	108,500.00
354	Хангамжийн материал	101,545,357.00	107,041,797.00
35410	Бичиг хэргийн материал	1,109,740.00	1,010,880.00
35420	Аж ахуйн материал	817,100.00	34,500.00
35450	Барилгын засварын материал	1,729,500.00	94,000.00
35470	Бусад хангамжийн материал	97,889,017.00	105,902,417.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,247,073,371.85	2,097,378,651.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,247,073,371.85	2,097,378,651.38
392	Биет хөрөнгө	2,230,147,371.89	2,080,562,651.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,343,977,796.64	2,343,977,796.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	(441,694,678.77)	(563,170,571.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	310,713,912.00	339,714,562.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(151,299,452.98)	(192,795,468.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	205,283,024.00	194,412,712.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(63,149,096.00)	(59,112,573.53)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,382,748.00	14,701,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,842,748.00)	(5,469,000.04)
39217	Ном	24,775,867.00	8,304,194.00
393	Биет бус хөрөнгө	16,925,999.96	16,815,999.92
39301	Програм хангамж	740,000.00	740,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(410,000.04)	(520,000.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,596,000.00	16,596,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,590,637,575.85	2,383,160,876.77
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	701,260.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	701,260.00	-
413	Өглөг	701,260.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	701,260.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,589,936,315.85	2,383,160,876.77
51	Засгийн газрын хувь оролцоо	2,589,936,315.85	2,383,160,876.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	280,983,355.00	280,983,355.00
51101	Өмч: - төрийн	280,983,355.00	280,983,355.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,101,211,361.83	894,435,922.75
51210	Өмнөх үеийн үр дүн	1,101,211,361.83	1,101,211,361.83
51220	Тайлант үеийн үр дүн	-	(206,775,439.08)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,207,741,599.02	1,207,741,599.02
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,590,637,575.85	2,383,160,876.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,573,663,017.00	1,893,538,821.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	797,614,017.00	38,661,621.90
120	Нийтлэг татварын бус орлого	797,614,017.00	38,661,621.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	75,250.00	210,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	75,250.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	797,538,767.00	32,027,200.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал	-	6,424,421.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,776,049,000.00	1,854,877,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,608,218,600.00	1,663,135,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,608,218,600.00	1,663,135,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	167,830,400.00	191,741,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	167,830,400.00	191,741,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,737,057,743.40	2,083,842,587.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,737,057,743.40	2,083,842,587.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,690,468,213.40	2,014,120,993.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,138,971,218.00	1,361,216,499.90
210101	Үндсэн цалин	728,612,691.00	793,253,457.90
210102	Нэмэгдэл	356,931,787.00	456,515,363.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	32,642,512.00
210104	Урамшуулал	53,426,740.00	78,805,167.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,819,787.00	169,277,590.00
210201	Тэтгэврийн даатгал	97,611,947.20	116,564,819.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,487,643.43	13,737,480.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,730,623.22	7,090,718.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,397,910.70	6,332,816.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,591,662.45	25,551,757.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,827,870.00	183,417,306.00
210301	Гэрэл, цахилгаан	9,497,470.00	12,675,939.00
210302	Түлш, халаалт	151,930,400.00	170,741,367.00
210303	Цэвэр, бохир ус	1,400,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	21,881,490.00	15,961,860.00
210401	Бичиг хэрэг	15,340,090.00	10,209,660.00
210402	Тээвэр, шатахуун	-	685,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,541,400.00	5,067,000.00
2105	Нормативт зардал	44,431,360.00	43,808,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,191,600.00	724,350.00
210502	Хоол, хүнс	43,239,760.00	43,084,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,716,050.00	7,330,500.00
210604	Урсгал засвар	3,716,050.00	7,330,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,993,248.00	15,492,358.61
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,993,248.00	15,492,358.61
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,827,190.40	217,616,029.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,140,264.00	11,799,182.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	146,686,926.40	205,816,847.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,589,530.00	69,721,594.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,578,000.00	68,392,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	46,578,000.00	68,392,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,530.00	1,329,094.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	836,605,273.60	(190,961,249.98)

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	16,471,673.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	16,471,673.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР	-	(16,471,673.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	836,605,273.60	(206,775,439.08)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,776,124,250.00	1,855,087,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	75,250.00	210,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	75,250.00	210,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	75,250.00	210,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	75,250.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,776,049,000.00	1,854,877,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,608,218,600.00	1,663,135,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,608,218,600.00	1,663,135,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	167,830,400.00	191,741,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	167,830,400.00	191,741,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,592,830,725.00	1,883,526,948.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,592,830,725.00	1,883,526,948.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,546,223,195.00	1,813,823,354.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,138,971,218.00	1,361,216,499.90
210101	Үндсэн цалин	731,036,024.00	793,253,457.90
210102	Нэмэгдэл	354,777,431.00	456,515,363.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	32,642,512.00
210104	Урамшуулал	53,157,763.00	78,805,167.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,792,925.00	169,441,098.00
210201	Тэтгэврийн даатгал	97,176,391.00	116,728,327.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,511,432.00	13,737,480.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,742,815.00	7,090,718.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,472,656.00	6,332,816.00
210205	Эрүүл мэндийн даатгал	21,889,631.00	25,551,757.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	162,827,870.00	183,417,306.00
210301	Гэрэл, цахилгаан	9,497,470.00	12,675,939.00
210302	Түлш, халаалт	151,930,400.00	170,741,367.00
210303	Цэвэр, бохир ус	1,400,000.00	-
2105	Нормативт зардал	42,538,500.00	43,785,760.00
210502	Хоол, хүнс	42,538,500.00	43,785,760.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,991,000.00	6,995,000.00
210604	Урсгал засвар	4,991,000.00	6,995,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,062,823.00	15,492,358.61
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,062,823.00	15,492,358.61
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,038,859.00	33,475,332.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,933,189.00	25,909,532.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,105,670.00	7,565,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,607,530.00	69,703,594.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,596,000.00	68,374,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	46,596,000.00	68,374,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,530.00	1,329,094.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	183,293,525.00	(28,439,748.51)

5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	44,940,800.00	40,566,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	44,940,800.00	40,566,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	44,940,800.00	40,566,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	44,940,800.00	40,566,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ((44,940,800.00)	(40,566,600.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	138,352,725.00	(69,006,348.51)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	98,697,282.00	237,050,007.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	237,050,007.00	168,043,658.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	280,983,355.00	1,207,741,599.02	264,606,088.23	-	1,753,331,042.25
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	280,983,355.00	1,207,741,599.02	264,606,088.23	-	1,753,331,042.25
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	836,605,273.60	-	836,605,273.60
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	280,983,355.00	1,207,741,599.02	1,101,211,361.83	-	2,589,936,315.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	280,983,355.00	1,207,741,599.02	1,101,211,361.83	-	2,589,936,315.85
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(206,775,439.08)	-	(206,775,439.08)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	280,983,355.00	1,207,741,599.02	894,435,922.75	-	2,383,160,876.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,900,052,100.00	1,663,345,800.00	236,706,300.00	87.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,679,104,900.00	1,663,135,800.00	15,969,100.00	99.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,679,104,900.00	1,663,135,800.00	15,969,100.00	99.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	220,947,200.00	210,000.00	220,737,200.00	0.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	567,800.00	210,000.00	357,800.00	37.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	220,379,400.00	0.00	220,379,400.00	0.0

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,900,052,100.00	1,732,352,148.51	167,699,951.49	91.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,900,052,100.00	1,732,352,148.51	167,699,951.49	91.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,825,661,900.00	1,663,977,648.51	161,684,251.49	91.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,488,533,300.00	1,361,216,499.90	127,316,800.10	91.4
210101	Үндсэн цалин	940,979,000.00	793,253,457.90	147,725,542.10	84.3
210102	Нэмэгдэл	503,184,000.00	456,515,363.00	46,668,637.00	90.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	32,642,512.00	(32,642,512.00)	
210104	Урамшуулал	44,370,300.00	78,805,167.00	(34,434,867.00)	177.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	186,066,500.00	169,441,098.00	16,625,402.00	91.1
210201	Тэтгэврийн даатгал	126,525,300.00	116,728,327.00	9,796,973.00	92.3
210202	Тэтгэмжийн даатгал	14,885,300.00	13,737,480.00	1,147,820.00	92.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,442,600.00	7,090,718.00	351,882.00	95.3
210204	Ажилгүйдлийн даатгал	7,442,600.00	6,332,816.00	1,109,784.00	85.1
210205	Эрүүл мэндийн даатгал	29,770,700.00	25,551,757.00	4,218,943.00	85.8
2105	Нормативт зардал	50,560,800.00	43,785,760.00	6,775,040.00	86.6
210502	Хоол, хүнс	50,560,800.00	43,785,760.00	6,775,040.00	86.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,153,700.00	15,492,358.61	7,661,341.39	66.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	23,153,700.00	15,492,358.61	7,661,341.39	66.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,347,600.00	74,041,932.00	3,305,668.00	95.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,781,800.00	66,476,132.00	3,305,668.00	95.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,565,800.00	7,565,800.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,390,200.00	68,374,500.00	6,015,700.00	91.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	74,390,200.00	68,374,500.00	6,015,700.00	91.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	74,390,200.00	68,374,500.00	6,015,700.00	91.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	237,050,007.00	(237,050,007.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	168,043,658.49	(168,043,658.49)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	48	47	1	97.9
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	34	33	1	97.1
620003	Үйлчлэх ажилтан	13	13	0	100.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутаг/

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	191,741,400.00	191,741,400.00	0.00	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	191,741,400.00	191,741,400.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	191,741,400.00	191,741,400.00	0.00	100.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	191,741,400.00	191,741,400.00	0.00	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,741,400.00	191,741,400.00	0.00	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	191,741,400.00	190,412,306.00	1,329,094.00	99.3

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	184,741,400.00	183,417,306.00	1,324,094.00	99.3
210301	Гэрэл, цахилгаан	13,000,000.00	12,675,939.00	324,061.00	97.5
210302	Түлш, халаалт	170,741,400.00	170,741,367.00	33.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	0.00	1,000,000.00	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,000,000.00	6,995,000.00	5,000.00	99.9
210604	Урсгал засвар	7,000,000.00	6,995,000.00	5,000.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1,329,094.00	(1,329,094.00)	
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	1,329,094.00	(1,329,094.00)	
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	1,329,094.00	(1,329,094.00)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг Боловсролын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм. Тус байгууллага нь сургалтын таатай орчин бүрдүүлсэн, чадвартай хөгжсөн багш ажилтантай, чанартай хүртээмжтэй сургалттай, стандартын шаардлагыг жигд хангасан, хүүхдэд ээлтэй сургууль болох зорилго тавьж, тайлант онд 357 сурагчидтай, 47 багш ажилчидтайгаар үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын дотоод аудит/аудиторын чиг үүргийг Боловсролын ерөнхий газрын дотоод аудитын нэгж хэрэгжүүлдэг ба тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон

бусад холбогдох хууль, журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,382,503.4 мянган төгрөг болж 8.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	237,050,007.00	168,043,658.49	(69,006,348.51)
Авлага	18,000.00	163,508.00	145,508.00
Бараа материал	106,496,197.00	117,575,058.90	11,078,861.90
Үндсэн хөрөнгө	2,247,073,371.85	2,097,378,651.38	(149,694,720.47)
Хуримтлагдсан элэгдэл	(667,395,975.79)	(821,067,613.26)	(153,671,637.47)
Өр төлбөр	701,260.00	-	(701,260.00)
Цэвэр хөрөнгө, өмч	2,589,936,315.85	2,383,160,876.77	(206,775,439.08)
Засгийн газрын хувь оролцоо	2,589,936,315.85	2,383,160,876.77	(206,775,439.08)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,590,637,575.85	2,383,160,876.77	(207,476,699.08)

Тайлант оны дансны үлдэгдэл оны эхний үлдэгдлээс 69,006.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 163.5 мянган төгрөг болж 145.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлтийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 117,575.0 мянган төгрөг болж оны эхний үлдэгдлээс 11,078.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 140,148.2 мянган төгрөг, аймгийн Боловсролын газраас 5,577.4 мянган төгрөгийн сурах бичиг, БОЯ-аас 867.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал шилжүүлэн авч нийт, 146,572.6 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 135,493.7 мянган төгрөгийн бараа материалыг тайлант онд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,097,378.7 мянган төгрөг болж оны эхний үлдэгдэл хөрөнгөөс 149,694.7 мянган төгрөгөөр буурсан шалтгаан нь тайлант онд Баян-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 8,000.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, БОУАӨС-ын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/325 тоот тушаалаар БОЯ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан 24,027.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 40,566.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үндсэн хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлж, Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025 оны

06 дугаар сарын 12-ны өдрийн 7/42 дугаар тогтоолоор 76,921.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан нь нөлөөлсөн байна.

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд программ хангамжийн төлбөрт урсгал зардлын төсвөөс нийт 12,597.8 мянган төгрөгийн төлбөр төлсөн байна. Үүнээс сургуулийн биет бус хөрөнгөд бүртгэлтэй Санхүүгийн тооцоолох групп ХХК-ын нийлүүлсэн нягтлан бодогч, нярвын программд 550.0 мянга, хөрөнгөд бүртгэлгүй төсвийн гүйцэтгэлийн мэдээ гаргах динамик программ болон сургалтын цахим хичээлийн программын төлбөрт 12,047.8 мянган төгрөгийг зарцуулжээ.

Тайлант онд өглөгийн оны эхний үлдэгдэл 701.3 мянган төгрөгийг бүрэн барагдуулж, өр төлбөргүй ажилласан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,400,044.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,400,044.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны харилцах дансны эхний үлдэгдэл 237,050.0 мянган төгрөг, улсын төсвийн санхүүжилтээс 1,663,135.8 мянга, өөрийн үйл ажиллагааны орлогоос 210.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,732,352.1 мянгөн төгрөг зарцуулж, тайлант оны харилцах дансны эцсийн үлдэгдэл 168,043.7 мянган төгрөг байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71802 Ерөнхий боловсрол					
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	2,064.7	2,063.1	1.6	99.9
2	80233 Хүүхэд хамгаалал	2,123.7	1,990.4	133.3	93.7
3	80312 Сургалт семинар	1,212.5	-	1,212.5	-
4	81605 Эрүүл мэндийг дэмжих	2,260.6	2,260.0	0.6	100.0
5	80101 Үдийн цай хөтөлбөр	74,390.2	68,374.5	6,015.7	91.9
6	80106 Дотуур байрны үйлчилгээ	380,831.4	300,802.2	80,029.2	79.0
7	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	40,393.3	40,393.3	-	100.0
8	81823 Боловсролын байгууллагын багш ажилтныг мэргэшүүлэх	5,408.0	3,508.0	1,900.0	64.9
9	81827 Бичиг үсгийн боловсрол хөтөлбөр	19,524.4	238.0	19,286.4	1.2
10	81834 Боловсролын стандарт, сургалт	1,321,706.8	1,268,539.6	53,167.2	96.0

11	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	40,819.2	37,180.8	3,638.4	91.1
12	81875 Сургалтын нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	9,317.3	7,002.3	2,315.0	75.2
Нийт		1,900,052.1	1,732,352.1	167,700.0	91.2

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ЕБС-ын захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар сургуулийн бүтцийг 50 орон тоогоор баталж, гүйцэтгэлээр 47 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд байгууллагын хоолны хөнгөлөлтөд төсөв батлагдаагүй бөгөөд Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын хавсралтын 8 дугаар зүйл 8.4 дэх заалтыг үндэслэн сургуулийн захирлын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/08 дугаар тушаалаар цалингийн санд багтаан олгох тушаал гаргасан бөгөөд нэг хүнд ногдох өдрийн хоолны хөнгөлөлтийн тарифыг 5.0 мянган төгрөгөөр тооцон олгожээ.

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь орон нутгийн төсвөөс 2025 онд 191,741.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд бүрэн зарцуулсан байна.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд 150,281.1 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

1. Тайлант онд худалдан авахаар төлөвлөсөн 67,784.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий “Дотуур байрны хоол хүнсний бараа, материал нийлүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог сургуулийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/02 дугаар тушаалаар томилж, ТБОНӨХБАУХАТХ-ийн 31 дүгээр зүйл 31.1.2-т заасны дагуу БХАБАӨСЕБС/20250202001 дугаартай тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулжээ. Тус тендерт “Бай Баян-Өндөр” хоршоо хамгийн бага үнийг саналыг ирүүлж, шалгарсан тул 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр 59,934.2 мянган төгрөгийн 25/02 тоот гэрээ байгуулжээ. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлээр 43,084.5 мянган төгрөгийн бараа нийлүүлснийг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр гэрээг дүгнэж, акт үйлдсэн байна.
2. “Үдийн цайны хоол хүнсний бараа, материал нийлүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Сургуулийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/03 дугаар тушаалаар томилж, БХАБАӨСЕБС/20250202002 дугаартай худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Тус тендерт “Бай Баян-Өндөр” хоршоо хамгийн бага үнийг саналыг ирүүлж, 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр 71,219.8 мянган төгрөгийн 25/03 тоот гэрээ байгуулан, гүйцэтгэлээр 68,392.5 мянган төгрөгийн бараа нийлүүлснийг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр гэрээг дүгнэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 97 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны улсын төсвөөс батлагдсан төсөв болох 1,899,484.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 18,994.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Батлагдсан төсвийг зориулалт ангиллын дагуу соортолж горим сорил гүйцэтгэхэд Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн асуудал гараагүй. .

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 101 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,673,482.5 мянган төгрөгийн 35 гүйлгээ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 185,577.8 мянган төгрөгийн 16 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 82 мэдээллийг бүрэн байршуулсан байна

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитыг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр гүйцэтгэсэн ба аудитаар хөрөнгийн тооллоготой холбоотой 24,294.2 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг залруулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2024 оны санхүүгийн тайлангийн аудитыг Баян ташаагийн эх ХХК -гүйцэтгэсэн бөгөөд аудитаар 755.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүлснийг явцаар бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	755.4	1	755.4	100
Албан шаардлага	1	-	1	-	100
Нийт дүн	2	755.4	2	755.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллага нь сургалтын үйл ажиллагаанд ашиглаж буй математик, англи хэлний хичээлийн программын үйлчилгээний төлбөрт тайлант онд 4,886.0 мянган төгрөг төлсөн байгаа асуудлыг дээд шатны захирагч анхаарах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24,951.7 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитаар залруулав. Үүнд:

1. Баян-Өндөр сумын ЕБС-ийн хөрөнгийн хагас жилийн тооллогоор "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох" төслийн санхүүжилтээр ирсэн 24,294.2 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэж тоолоогүй байсныг завсрын аудитаар залруулав.

Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, НББОУС-16 Үндсэн хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-т Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтад нийцэхгүй байна.

2. Тайлант онд Боловсролын газраас хүлээн авсан номын үнийг тусгай зориулалтын материалын тайланд 657.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байсныг аудитын явцад залруулав.

Энэ нь УСНББОУС-12 Бараа материал, НББОУС-2 Бараа материал, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-т "Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Аудитаар 1 зөрчил² илэрсэнд албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс материаллаг зөрчил илрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 8,298 м.кв хэмжээтэй, 6425000106 нэгж талбарын дугаар бүхий газрын мэдээллийг Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад 5,947 м.кв газар дутуу, нэгж талбарын дугаар зөрүүтэй байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", 13 дугаар зүйл, 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын нэр дээр бүртгэлтэй газрын хэмжээг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай тулган баталгаажуулж нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусган зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тусгай зориулалтын бараа материалын дансанд түрээсийн номны орлогыг 657.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	657.5	1	657.5			1	657.5		
Дүн	1	657.5	1	657.5			1	657.5		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 618м.кв талбай бүхий газрын мэдээллийг Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад 882.0 м.кв газар дутуу зөрүүтэй байна	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oO-----